

## “Цаг Хугацаа орон зай хамааралгүй зурган дээрээ залбирал аван цусны цагаан бөөмний өвчнөөс эдгэрсэн нь”

Мари Тереса итгэгч (Франц Манмин Сүм)



2011 оны Наймдугаар сард Мари Тереса (зүүн талд) Доктор И Жей руг пастор уулзан талархаж байгаа байдал. Виржиния (баруун талд) Манмин Төв Сүмийн Эзний өдрийн мөргөлийн Франц хэлний орчуулагч

Би долоон жилийн турш цусны цагаан бөөмний өвчнөөр зовж байв. 2000 оноос эхлээд миний биеийн байдал маш их дордон өдрөөс өдөрт муудаж байв. Эмнэлэгт очин эмчийн үзлэгт орсон боловч шинжилгээний хариу нь цусны цагаан бөөмний өвчтэй хэмээн гарсан нь миний бодож санасанаас өөр байв. Тиймд эдгэрэхийн тулд өөртөө хэрэгтэй гэх бүх эмийг хэрэглэсэн боловч миний биеийн байдал сайжрахгүй харин ч маш улам муудаж байлаа. Түүнээс хойш 1 жилийн дараа дахин шинжилгээнд орсон бөгөөд хариу нь цусны цагаан бөөмний өвчний хүнд үедээ орсон гэдгийг надад хэлэв.

Үхлийн ирмэг дээр ирэхэд Солонгост амьдарч байгаа Виржиния охин маань гэнэт санагдав. Би утасдан охиндоо цусны цагаан бөөмний өвчтэй гэдгээ хэлсэн ч хүнд үедээ орсон тухайгаа хэлээгүй юм. Бага байхдаа эцгээ алдсан охиноо бодон одоо ээжийгээ алдах гэж байна гэдгийг хэлэхээсээ их санаа зовж байв. Энэ мэдээлэл түүнд маш хүнд шокилт болох байх хэмээн бодож байв. Удалгүй миний биеийн байдал улам муудан би юм илэж ууж ч чадахгүй болов. Идсэн ууснаа бөөлжин гаргадаг болсон тул миний бие байдал маш хүнд болгов.

Өвдөхийн өмнө би 100 кг жинтэй байсан бол одоо 38 кг жинтэй болсон байлаа. Тиймээс би бүх л зүйлээ татгалзаж амьдралаа иргэцэн гэрээслэл үлдээж үнэт зүйлсээ Солонгост амьдарч байгаа Виржиния

охиндоо илгээв. Гэтэл охин маань өөрийн очдог Солонгос Манмин Төв Сүмийн тухай дурдан ярьж байсан ба Доктор И Жей руг пасторын тухай түүгээр дамжуулан эрх мэдэлт хүчтэй үйлсүүд, төрөл бүрийн өвчнөөсөн эдгэрч байсан хүмүүсүүдийн гайхамшигтай гэрчлэлүүдийг ярьж өгсөн юм.

Солонгост очоод Доктор И Жей руг пастораас биеэрээ залбирал аваагүй байсан ч гэсэн зурган дээрээ залбирал авахад л бүрэн эдгэрэх боломжтой тухай надад хэлэв. Тэгэхэд нь би охиндоо “Би хүнд өвчин туссан ба удаан амьдрах боломжгүй” гэдгээ хэлэхээс өөр аргагүй байдалд оров. Гэвч охин минь миний хэлсэн үгэнд огтхон ч санаа зовж сандарсангүй харин ч “Доктор И Жей руг пастораас залбирал авбал заавал эдгэрэх болно” гэдэгт итгэж байна гэж охин минь хэлж байсан юм.

2004 оны Тавдугаар сард, Доктор И Жей руг пастор миний зурган дээр залбирал хийж өгсөн юм. Хэдий тийм боловч надад ямар ч өөрчлөлт орсонгүй. Энэ үед миний охин яагаад намайг эдгэрэхгүй байгаагийн учир шалтгааныг хайх хэрэгтэй юм. Үнэн хэрэгтээ би эдгэрлийн залбирал авахын тулд гэм нүглээ гэмшсэний дараа итгэлээрээ залбирал авах ёстой байтал би тэгж чадаагүй юм. Тиймээс охин минь зөвт нэгэний залбирал, хайрын залбиралд хариулж өгдөг Бурхан(Иаков 5:16) ыг түшиглэн өөрийнх нь залбиралд

## “Сайхан зүрх сэтгэлийг бий болгож, тасарсан булчинг минь эдгээж өгсөн юм”

Су Ви мин эгч дүү (Оюутны 1-р баг)

Өнгөрсөн 6-р сарын сүүлээр би ээжтэйгээ хамт машинаар явж байсан юм. Ээж маань “намайг оройн цагаар хүнтэй утсаар битгий ярьж бай” хэмээн хэлж байсан нь намайг тавгүйтүүлсэн юм. Тэгээд тэр үед гэрлэн дохион улаан гэрэл асаж машин хурдаа сааруулан зогсох шиг болоход нь би уурандаа буусан юм. Хэдий тийм боловч машин миний бодож байснаас илүү хурдтай байсан тул би буухдаа зогсож ч чадаагүй унасан бөгөөд хөлийн шагай хавиар маш их өвдөж байлаа. Миний зүүн хөлийн шагай хөхрөн их хавдсан байлаа. Гэсэн ч би ингэж байгаад гайгүй болно гэж бодоод нэг их тоолгүй орхив.




Өвдөлтийг нь гэсвэрлэн хөл дээрээ догонцон байж сүмдээ ирж мөргөлдөө суугаад Доктор И Жей руг пасторын өвчтөний төлөөх залбирлыг авч, Эрх мэдэлт хүчтэй Мүан амтат ус (Доктор И Жей руг пасторын залбирал далайн эргийн шорвог ус амтат ус болж хувирсан Е.Г 15: 25) шүршлээ.Түүнээс хойш өдөр өнгөрөх тусам хөл сайжирч чөлөөтэй алхдаг болж Сүмийнхээ оюутны багийн урлагын хэсэгт үүргээ гүйцэтгээр байсан юм.

Наймдугаар сарын 23-нд, эмнэлэгт очин үзүүлэхэд эмч надад шагайн яс ойролцоох булчингуудын зарим нь тасарсан учраас сэргээн эмчлэхэд мээ заслын аргаар залгах хэрэгтэй гэсэн боловч миний булчингууд маш нарийн байсан тул мээ засал хийх боломжгүй гэж хэлсэн юм. Хэдий ийм байдалд байхад минь надад алхах боломжгүй өгсөн Бурхан Аавдаа их баярлан талархаж байв. Тэгээд би сэтгэлдээ тогс эдгэрье хэмээн шийдлээ.

Бурханы өмнө ээждээ уурлан бухимдаж байснаа гэмшин, өөрийн уур бухимдаа хаяж эхлэв. Есдүгээр сарын 2-ны Баасан гаригт би Доктор И Жей руг пастораас дахин залбирал авахад “би бүрэн эдгэрлээ” гэсэн итгэл төрөв. Эзний өдөр сүмдээ суугаад маргааш нь Есдүгээр сарын 5-нд, ЭХО шинжилгээ болон зургыг нь авахуулахад миний шагай хэвийн болсон байв. Халлелуяа!

Энэ үйл явдал миний итгэлийг улам өсгөсөн бөгөөд Эзний агуу халуун хайрыг мэдэрсэн ерөөлт цаг мөчүүд байлаа. Намайг эдгээж өгч сайхан сэтгэлийг бий болгож өгсөн Бурхан Аавдаа, Хайрт Эзэндээ, талархал ба алдрыг өргөж мөн Доктор И Жей руг пастортаа чин сэтгэлээсээ талархлаа илэрхийлэе!



Залбирал авахын өмнө нь: Хөлийн шагайн булчингийн гэмтэл авсан байгаа байдал / Залбирал авсаны дараа нь: Хаван нь буун булчингийн гэмтэл нь эдгэрсэн байгаа байдал

# Манмин Мэдээ

Номер 18 2011 оны Арван хоёрдугаар сарын 11

## Африк өмнөд Суданы бүгд найрамдах улсад болсон Ариун Сүнсний гайхамшигт үйлсүүд!



Африк дахь Есүс Христийн Нэгдсэн Ариун урсгалын сүмийн удирдагч Доктор Жон мёон хо пасторыг урьж Африк Өмнөд Суданд болсон номлогч нарын семинар болон гар алчуурын цуглаанд гайхамшигт эдгэрлийн үйлсүүд маш их илчлэгдсэн бөгөөд Амьд оршигч Бурхандаа талархал ба алдрыг өргөе!

### Есүс Христийн Африкийн Нэгдсэн Ариун урсгалын сүмийн удирдагч Доктор Жон мёон хо пасторыг урьсан номлогч нарын семинар болон гар алчуурын цуглаанд 30,000 хүн оролцов.



Суданы бүгд найрамдах улс бол Африкийн хамгийн том улс юм. Суданы хойд хэсэгт амьдрах Арабууд болон өмнө зүгт амьдарцаах Судан нутгийн уугуул иргэдийн хооронд соёл иргэншил болон шашины мөргөлдөөн зэрчил тасралтгүй үргэлжилсээр байгаа билээ. 50

ж и л и н турш дайн дажин үргэлжилсэний эцэст 2011 оны 7-р сард Өмнөд Судан нь Хойд Суданаас салан тусгаар тогтнолоо олж авсан ч бодит байдал улам хүнд болсон юм.

Хүн амын 90% нь өдрийн орлого 1 ам доллар төдийхнөөр амь зуух зэрэг туйлын ядуу байдал болон олон жилийн турш үргэлжилсэн дотоодын дайн самуун, гай гамшгаас болоод өнөөг хүртэл нутгийн ард иргэд маш их зовлон амсаар байгаа билээ. Хойд Судан руу дүрвэн зугтаасан хүмүүс эргэн эх орондоо ирчгэн эрх чөлөөтэй байгаа боловч ихэнхи хэсгийн амьдрал туйлын хүнд бөгөөд орон байр болон хоол хүнсний дутагдалд үргэлж байдаг учир асрамж эсвэл түр орогнох газар байсаар байгаа билээ. Хүүхэд багачууд нь шар ханиад болон малария өвчнүүдээр нас барсаар л.

Ийм нөхцөл байдал дотор Өмнөд Суданы үндэсний парламентын дэд дарга Даниел Авет Акотын урилгаар нийслэл Жуба хотод Есүс Христийн Африкийн Нэгдсэн Ариун урсгалын сүмийн удирдагч Доктор Жон мёон хо пастор Номлогч нарын семинар болон Гар алчуурын цуглааныг удирдан явуулав.

Өнгөрөгч аравдугаар сарын 28-нд, Доктор Жон Мёон хо пастор Өмнөд Суданы парламентийн ордонд парламентийн гишүүд болон сайд нарт хандан “Бүхнийг Бүтээгч Бурхан”, “Есүс Христ” болон Доктор И Жей руг Тэргүүн пасторын тухай танилцуулж, сургаал айлдсаныхаа дараа Өмнөд Суданы ерөнхийлөгч болон ард түмний төлөө ерөөлийн залбирал хийсэн юм. Мөн тэр өдрөө тэрээр Жуба хотын христийн сүмд болсон номлогч нарын семинар дээр Иовын номноос сургаал айлдсан юм. Үүгээр дамжуулан олон сүмүүд Манмины салбар цуглаан болохоор нэгдсэн юм.

Аравдугаар сарын 29, 30-нд болсон Гар алчуурын цуглааны үйл ажиллагаанд нийт гучин мянган хүмүүс хүрэлцэн ирцгээв. Жон мёон хо пастор нь Үйлс 4:12 болон Лук 5:1-9-д дурьдсанчлан “Зөвхөн Есүс христээр л дамжуулан аврагдах боломжтой бөгөөд өөрийн гэм нүглээ хүлээж, гэмшихэд Бурханы хүч чадлыг мэдрэх болно” хэмээн сургаал айлдсан билээ. Түүний дараа тэрээр өвчтэй хүмүүсийн төлөө гар алчуурын залбирал хийхэд хараагүй хүмүүс хараа орж, сонсоггүй хүмүүс сонсож эхлэн, хэлгүй хүмүүс ч хэл оршгоож, таягтай хүмүүс таягаа хаан тэргэнцрээр түрсээр индэр рүү гарч ирэн өвчнөөсөө эдгэрсэн тухайгаа гэрчлэх хүмүүсийн тоо маш их байсан бөгөөд бүгд баярлалдан дуу алдан хашгирагаж байлаа.

Энэ цуглалалтаар дамжуулан Өмнөд Суданы ард иргэд агуу гайхамшиг үйлсээрээ хамт байсан Бурхантай уулзан,Түүний дотор амар амгалан ба найдварын гэрлийг харцагаасан юм. Мөн үндэсний парламентын дэд дарга Даниел Авет Акот гуай Доктор И Жей руг пасторд хандан талархалын жуух бичиг илгээсэн билээ.

### Вьетнам хэлээр “Загалмайн Үг” болон “Миний Амьдрал Миний Итгэл I” ном тус тус хэвлэгдэн гарав

Доктор И Жей руг пасторын намтар түүх болох “Миний Амьдрал Миний Итгэл I” хэмээх ном болон “Загалмайн Үг” ном нь Вьетнам улсын засгийн газрын зөвшөөрөлтэйгээр тус улсад хэвлэгдэн гарав. Вьетнамын Хо Чи Мин Манмин сүмийн хариуцагч пастор Давид Нам гуай хэлэхдээ, “Вьетнамд Христэд итгэгчид зориулсан ном хэвлэгдэн гарах зөвшөөрлийг засгийн газар хүлээн зөвшөөрсөн нь үнэхээр гайхамшигтай тохиолдол билээ. Энэхүү боломжийг бий болгосон Бурхан Эцэгтээ болон үүний төлөө залбирч өгсөн Доктор И Жей руг пастортаа болон Манмин Төв Сүмийнхэнд талархалаа илэрхийлмээр байна хэмээн дурдан хэлэв.”



Ивээл дүүрэн сургаал ба Христмас баярын гэрэл асаах ёслол ба олон төрлийн үйл ажиллагаа хүндэт таныг урьж байна.

Хэзээ: 12 сарын 16нд 18цагт.  
Хаана: Бүх ариун үндэстэн Христийн чуулганд

Христмас баярын үйл ажиллагаанд мөн эрхэм таныг урьж байна. Үүнд Христмас баярын бэлэг таныг хүлээж байна.

Хэзээ: 12 сарын 24нд 17 цагт. 25нд 10 цагаас тус тус явагдана.  
Хаана: Бүх ариун үндэстэн Христийн чуулганд

Мөргөлийн цаг		Залбирлын цаг		Монгол Манмин Төв Сүм	
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч	
Их мөргөл	Ням гариг 10: 30	Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золяяа (Том хүний баг хариуцагч)	
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40				
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00	Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)	
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00				
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30				
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30	Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)	

**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С

**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 917-0773

www.manmin.org  
www.manmintv.org



“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд (16)

# Есүсийн хөл Хугалагдаагүйн утга учир ба Есүс цус ба усаа урсгасны сүнс зүгийн утга

“Харин Есүс уруу ирээд Түүний хэдийн үхсэн байхыг тэд үзээд, хөлийг нь хугалсангүй. Цэргүүдийн нэг нь Түүнийг хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо.” (Иохан 19: 33-34).

Бид Есүсийн туулсан хүнд зовлон бэрхшээлийн учир шалтгааныг ойлговол Бурханы хайрыг хүнээ ухаарах бөгөөд тууштай халуун итгэлийн амьдралаар амьдрах боломжтой билээ. Энэ удаад та бүхэндээ загалмайд цовдлогдсон Есүсийн хөлийг хугалалгүй үлдээсний учир болон мөн Тэрээр бүхий л цус болон усаа урсгасны учир шалтгааныг тайлбарлах болно.

## 1. Есүсийн хөл нь хугарахгүй байх нь Бурханы чин хүсэл байсан билээ

Есүс загалмай дээр олон цагын турш маш хэцүү зовлонг амсаж байгаад эцэст нь амьсгал хураасан билээ. Тэр өдөр нь баасан гариг байсан бөгөөд дараах өдөр буюу бямба гариг нь Иудейчүүдийн ариунаар сахидаг амралтын өдөр байсан тул загалмайд цовдлогдсон цогцосыг тэр модон дээр нь үлдээх ёсгүй байсан билээ. Тийм ч учраас Иудейчууд захирагч Понти Пилатаас гэмт хэрэгтнүүдийн цогцосуудыг загалмайнаас буулган хаяхыг хүсдэг байсныг харж болно. (Иохан 19:31).

Ромын цэргүүд Есүсийн хоёр талд цовдлогдсон байсан хоёр дээрмчдийн хөлийг хугалан цогцсыг нь авч хаясан билээ. Мөн энэ загалмайд цовдлуулсан хүний хөлийг хугалвал тэр хүнийг, хурдан үхүүлэх ба хөл дээрээ зогсож чадахгүй зугтаалгахгүйн үүднээс хугалдаг юм. Учир нь загалмайд хадагсан хүн доошоо унжиж буй биеэ өргөж жаахан ч гэсэн өвдөлтийг тэсвэрлэх гэж хөлөөрөө жийдэг бөгөөд энэ л үед хөлийг хугалвал тулж түших чадваргүй болж амьсгал хураадаг билээ. Гэвч Есүс нь аль хэдийнээ амьсгаа хураасан байгааг ажигласан тэд хөлийг нь хугалаагүй билээ.

Дуулаал 34: 19-20-д, “Зөв шударга хүний зовлон зүдгүүр их байдаг, Харин ЭЗЭН түүнийг тэр бүгдээс нь авардаг. Тэр түүний бүх ясыг хамгаалдаг, Тэднээс нэг нь ч хугараагүй юм.” хэмээн дурдан бичсэн байдаг. Хэдийгээр Есүс бүх хүн төрөлхтөний гэм нүглийг өөртөө хүлээн авч модон загалмайн дээр цовдлуулсан боловч Тэр Өөрөө бол гэм нүгэлтэн биш Зөвт байсан тул Бурхан Есүсийн хөлийг гэмтээлгүй авран хамгаалсан билээ.

Мөн Египетээс гарсан нь 12:46 дээр болон Тоолого 9:12-д Бурхан Израйльчуудад “Тэд хургыг идэх болно гэхдээ ямар ч ясыг нь хугалалгүй байх ёстой” хэмээн зарлиг болгосон байдаг. Библи дээрх “хурга” хэмээн дурдаж байдаг нь Есүсийг төлөөлөн хэлж байгаа билээ. (Иохан 1:29). Тийм учраас Есүсийг төлөөлж буй хурганы ясыг бүү хугал хэмээн тушаасан бөгөөд энэхүү



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

зөгнөлийн биелэлийг бий болгохын тулд Есүсийн ясыг хугалаагүй билээ.

## 2. Есүсийн цус ба ус урсгасны учир

Иохан 19:34-д, “Цэргүүдийн нэг нь Түүнийг хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо”, хэмээн айлдсанчлан хэдийн амьсгал хураасан байсан Есүсийн хажуу хавирга руу Ромын цэрэг жадаар чичлэн хатгадаг. Өргөст итгэм зүүн, бүх л бие нь ташуурдуулан зодуулснаас болсон шарх болон загалмайд хадагдсан гар хөлнөөс нь цус урсан дусалж байгаа Есүсийг харахад үнэхээр нүд халтирам аймшигт дүр төрх байв. Гэтэл тийм аймшигт дүр нөхцөл байдалд байгаа Есүсийг үхсэн эсэхийг шалгахын үүднээс Түүний хажуу хавирга руу хатгаж байгаа Ромын цэрэг нь үнэхээр хүн төрөлхтөн хичнээн харгис хэргийг, атгаг, хорон муу гэдгийг үзүүлж байгаа юм.

Тэгвэл Есүс хажуу хавирга руу нь жадлан хатгуулахад цус ба ус урсгасны учир шалтгаан нь юу юм бол?

Нэгд, Иохан 1: 14-д үзвэл Есүсийг ямар Эрхэм болохыг мэдэж болох юм. “Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан,” гэж айлдсан бөгөөд Сүнсэлэг Бурхан хүний биеийг өмсөн энэ дэлхий хүний биеэр ирсэн гэдгийг батлаж байгаа хэрэг юм. Есүс нь эцэг эхийнхээ эр эм эсээр бүрэлдсэн биш Ариун Сүнсээр энэ газар дээр төрсөн билээ. Түүнчлэн Тэрээр хүний биеэр төрсөн учир хүнтэй мөн адил бие махбодийн өсөлт хөгжлийн үйл явцыг бүгдийг мэдэрч туулж ирсэн болохоор хүн төрөлхтөнийг аврах мэдэрч болох мөн бодол санаа, сэтгэлийн хөдлөлийг мэдэрч байсан ч гэсэн Тэрээр зөвхөн үнэн дотор

Хүн төрөлхтөний Аврагч болох

шудрагаар амьдарч байлаа. Үүнтэй адил, бид ч гэсэн Аврагч Есүс шиг ариухан бөгөөд төгс төгөлдөр Есүс Христийн зүрх сэтгэлийг дуурайн, бурханлаг мөн чанарын хуваалцагч болох боломжтой билээ.

Хэн ч гэсэн Эзэнд итгэн, гал мэт халуун залбиран, хичээн зүтгэж Бурханы ивээл ба хүчийг аван Ариун Сүнсний тусламжтайгаар гэм нүглийг төгс хаях боломжтой юм. “Есүс бол Бурханы Хүү тул ариухнаар амьдрах боломжтой байсан ч би сул дорой хүн учраас тэгж чадахгүй нээ” гэж шалтгаалах боломжгүй нь ойлгомжтой юм.

Гуравт, Угийн гэм нүгэл ба хийсэн гэм нүгэл ч байхгүй Есүсийн цус бол ямар ч толбогүй бөгөөд өө сэвгүй цэвэрхэн үнэт цус билээ. Ийм үнэт цусаар бид итгэлээрээ гэм нүглээсээ уучлагдан мөнх амийг хүлээж авдаг. Түүнчлэн, ус гэдэг нь сүнсэлэг утгаараа “Үг”ийг төлөөлөн хэлж байгаа ба Бурханы Үгийн сонсон төрчлэн дагах тусам гэм нүглээсээ ангижран ариун шудрага зөвт болдог билээ.

Тиймээс Есүсийн урсгасан цус ба ус нь биднийг бүрэн өөрчлөх хүчтэй бөгөөд үхлээс аврах амийн цус ба ус билээ. Есүсийн хажуу хавирга руу жадлан хатгахад цус болон ус урссан нь бид Есүсийн золиослолоор дамжуулан гэмээсээ уучлагдаж, Бурханы үгийн дагуу амьдрах хүчийг олон жинхэнэ амьдралыг олсныг илтгэж байгаа юм. Хайрт ах эгч дүүс нараа, Есүс Өөрийн биеэр өвдөлт ба зовлонг туулснаараа үй олон хүмүүс аврал хүртэх боломжтой болохыг болон Түүний гайхамшигт аялалтаар олон хүмүүс мөнх амь ба аз жаргалтай болохыг мэдэж байсан болохоор баяр хурдан хурдан дотор зовлонгийн замаар явсан билээ. Өөр хэн нэгний төлөө бус харин биднийг аврахын төлөө бүхий л зовлон хавчлагыг тэвшин туулж, цус ба усаа урсгасан билээ.

Тиймд Эзэний хайрыг гүнээ ухаарч маш хурдан гэм нүглээ хаяж, алдагдсан бурханлаг мөн чанараа сэргэсэнээр үзэсгэлэнт Тэнгэрийн улсад мөнхөд аз жаргал ба баяр хөөрийг эдлэхийг Их Эзэний нэрээр хүсэн ерөөж байна!

Мөн Филиппой 2: 5-д, “Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай.” хэмээн айлдсан байдаг ба 2 Петр 1: 4-д, үзвэл “Эдгээрээр дамжуулан Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхсон. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарын хуваалцагч болох юм.” хэмээн дурдсан байдаг.

Есүс нь бусад хүний адил бие махбодтой байхдаа ямар ч гэм нүгэл үйлдээгүй бөгөөд ариухан амьдралаар амьдарсан билээ. Хүүүүстэй адил өсч бойжин, хүний мэдэрч болох мөн бодол санаа, сэтгэлийн хөдлөлийг мэдэрч байсан ч гэсэн Тэрээр зөвхөн үнэн дотор

Mongolian

**Манмин Мэдээ**  
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул, 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
e-mail: manminministry@hotmail.com  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

# “Мэс заслын төлбөр 35 сая вон хэмнэчихлээ”



Гү Өнь хэ эгч дүү (Донг яан Нисахийн Их Сургуулийн 4-р курсийн оюутан, Чүнчон Манмин сүм)

Би Христчин гэр бүлд төрсөн бөгөөд багаасаа эцэг эхийгээ даган сүм рүү ирж очдог л нэгэн байсан бөгөөд жинхэнэ христчин хүн биш байлаа.

2008 оны Наймдугаар сард Хятадын Чингдао мужид байрлах Чингдао Их Сургуулийн оюутан солилцоогоор суралцах боломжтой болов. Их сургуулийн оюутан болсноор эрх дураараа байх гэсэн хүсэл минь биелж, гадаадад хэн нэгэн надад зааж, зэмлэх хүнгүй тул амьдрал минь их эмх замбараагүй болов. Найз нөхөдтэйгэй байнга энд тэнд дэмий зугаалан ням гаригт Эзэний өдөр сахихаар Сүмд ч очихоо болив.

Солонгос

руугаа буцан ирэхээс нэг сарын өмнөөс эхлээд би хоол идэхдээ зажлж идэж чадахгүй болов. Юм ярихад ч гэсэн бэрхшээлтэй болов. Дараа нь харгал миний дээд доод үүдэн шүднүүд минь нийлэхээ больж хоорондоо зай гарснаар бүр хуруу орох хэмжээний болох тэр үед би санаа зовж эхлээд.

2009 оны Нэгдүгээр сард би Сөүлийн нэгэн эмнэлэгт очиж үзүүлэхэд намайг зажлуур болон эрүүний яс ба булчингийн гаж хөгжилтэй хэмээн оношлов. Хойд араа шүднээс бусад шүднүүд маань хоорондоо маш их зайтай болон би амаа ч хамхиж чадахгүй болов.

Шүд засах бүслүүр тавьсан ч гэсэн засагдахгүй гэсэн бөгөөд эрүүний мээ засалд тул хагалгаанд орох хэрэгтэй гэв. Гэвч нэг талын эрүүний ясны мээ засалд ороход 35сая вон болно гэдгийг олж мэдлээ. Эцэст нь нь би 5 сард мэс засалд орохын оронд шүдний буйланд

шигтгэдэг шүд тэгшилдэг тусгай бүслүүр төмөр суурилуулахаар болов. Ингээд юм идэж уух болон унтахад ч гэсэн маш төвөгтэй байлаа.

Тэр үеэс арван сарын дараа 2010 оны Гуравдугаар сард, эмч дээрээ очиж үзүүлэхэд сүүлийн хоёр сараас эхлээд миний шүдэнд хийсэн байсан төмөр бүслүүр нь суларсан байна гэдгийг болон зайлшгүй мэс засалд орох хэрэгтэй тул 7 хоногийн дараа дахиад ир гэж эмч хэлсэн юм. Ингээд Арван сарын турш тийнхүү төмөр бүслүүртэй байсан нь ямар ч ашиггүй байсан гэдгийг мэдэн тэр хугацаанд маш их өвдөлт зовиураа санаад өөрийн эрхгүй уйсан юм.

Яг тэр үед Сөүлд амьдардаг миний нагац эгч (Ким Мёонг суг халамжлагч) боломж л гарвал Доктор И Жей руг пасторын тухай болон эрх мэдэлт хүний гайхамшигт гэрчлэлүүдийг надад ярьж өгдөг байв. Шиврээ бороо хувцас норгодог гэдэг шиг үүнийг сонсоод миний итгэл бага багаар нэмэгдсээр байв. Тиймээс миний ээж бид хоёр хааяа Сөүлд ирэхээрээ Манмин Төв Сүм дээр очиж мөргөлд оролсон Доктор И Жей руг пасторын өвчтөний төлөөх залбиралыг хүлээж авдаг байв. Мөн интернэтээр ч хэдэн удаа залбиралыг хүлээн авдаг байсан ба тэгж байх үед шүд хөлдөх мэт мэдрэгддэг байсан бөгөөд “Бурхан эдгээж өгч байх нээ” гэсэн итгэл төрсөн юм.

2010 оны Гуравдугаар сарын 31-нд, И Хи Сон пасторын удирдлага дотор Чүнчон Манмин Сүмд гар алчуурын цуглаан болоход би ээжтэйгээ хамт очив. (Үйлс 19:11-12). Сургаал сонсоод их ивээл хүртсэн бөгөөд энэ хугацаанд үйлдсэн өөрийн гэм буруутай байдалаа эргэн санан гэмшиж, ялангуяа Хятадал байхдаа эмх замбараагүй байсан амьдралаа эргэн харж чин сэтгэлээсээ гэмшлээ. Түүний дараа сургаал айлдагчаас гар алчуурын залбирал (Үйлс 19:11-12) авсан юм. Тэгэхэд миний бие маш их халуу дүүгж миний шүд ч их өвдөж байлаа. Дараахан нь би толинд харахад би амаа ч хамхиж чадахгүй байсан би амаа чөлөөтэй хааж шүд бараг нийлсэн байлаа. Бурхан Ариун Сүнсний галаар шүдийг минь хэвэнд нь оруулж эдгээн өгсөн билээ.

Тэр долоо хоногын Баасан гаригт би эмнэлэг дээр ээжтэйгээ хамт явж очлоо. Эмч миний шүдийг үзээд

маш их гайхан хэлэхдээ, чи мэс заслын мөнгө 35сая вон хэмнэчихлээ ш дээ хэмээн хэлэв. Мэс засалд орохоос өөр аргагүй байдалд орсон би одоо мэс засалд орох ч шаардлагагүй эдгээснээ маш их баярлав. Халлелуяа!

Үнэндээ мэс засалд орсны дараа ч гэсэн зургаа долоон жилийн турш шүдний бүслүүр зүүх хэрэглэх ёстой байлаа. Гэвч би 1 жил ч хурьгүй хугацаанд эдгэсэн тул Бурханы энэрэл ивээлд үлгэрлэж талархаж байна. Яг тэр өдөр, Баасан гаригийн оройн мөргөлд оролцохоор би Сөүлд хүрч ирээд Доктор И Жей руг пасторд талархсанаа илэрхийлж мөн өвчнөөсөө эдгэрсэн тухайгаа гэрчилсэн юм. Доктор И Жей руг пастор маань ч намайг эдгээснээ маш их баярлан надад дахин залбирал хийж өгөв. Тэр өдөр миний шүд улам их сайжирсан бөгөөд одоо би шүдний бүслүүр зүүх ямар ч шаардлагагүй болсон билээ.

Надад дурдах бас нэгэн гайхамшигт гэрчлэл байгаа билээ. Энэ жилд эхний хагаст болсон “2 удаагийн Онцгой Даниел Залбирал”-ын цагт миний нүүрний хэв магь маань өөрчлөгдсөн гайхамшигт зүйл тохиолдов. Урьд нь гурвалжин хэлбэртэй нүүр царайтай байдаг байсан ба үзээ хойшоо шуухаар туранхай эвгүй харагддаг байлаа. Одоо зуван сайхан нүүртэй болсон тул үзээ хойшоо шууж боохоор яг зохицон сайхан харагддаг болсон юм. Сүмд явдаг гэх боловч Бурханы үгийг огт хайхралгүй явж байсан надад энэ мэт эрхэм нандин зүйлийг мэдрүүлж өгсөн Бурхан Авдаа, хайрт Эзэндээ талархал алдрыг өргөн барьяа!



Тухайн үед шүдний байдал нь маш хүнд байдалтай бөгөөд мэс засалд орсон ч гэсэн 6,7 жил зүүх ёстой байв. Өөр ямар нэгэн аргаар огт нийлүүлэх боломжгүй байсан шүднүүддээ залбирал хүлээн авсаны дараа түүний шүд нь хэвийн байдалд орон эрүүл болсон байгаа байдал.

# “Эрх мэдэлт хүчит гар алчуураар залбирал хийхэд үхэж буй охиныг аварсан юм”

Пастор Ворон Инватнакун (Тайланд Чай Пракан Манмин Сүм)



2011 оны Дөрөвдүгээр 19 сард манай сүмийн нэгэн итгэгч над руу маш яаралтай утасдаж залбирал хийж өгөөч гэж хүссэн юм. Тэр надад хэлэхдээ Тайландын хил даван Мьянмарын Мүвансат хотод амьдардаг түүний 17 настай үеэл охин дүү Ротчана Понгсук нь авто осолд ороод долоо хоног ухаангүй байсан бөгөөд тэрээр хамаатнуудынхаа хамтаар Тайландын хилийн хамгаалалтын албаны хүмүүсийн тусламжтайгаар Тайлаандад хүрч иржээ. Дөрөвдүгээр сарын 21-нд би анх түүнийг харахад ямар ч ухаангүй бүх бие нь саажилттай хэвтэж байв. Миний амьдардаг газрын ойролцоо байх Маеай эмнэлэг рүү аваачиж хэвтүүлэх гэсэн боловч томоохон осолд орсон тул том эмнэлэгт очихыг тэд зөвлөж байлаа. Дараа өдөр нь ЧиАн рай дахь эмнэлэгт хэвтүүлэв. Эмчилгээ хариуцсан эмч нь хэлэхдээ “Өвчтөний толгойноос цус их алдсан тул мэс засал хийх боломжгүй” гэж хэлсэн юм. Тэгтэл Чи Анрай Манмин сүмийн номлогч И Жей вон болон түүний эхнэр хоёрыг тэр охины төлөө залбирал хийж өгөөч хэмээн аминчлан хүсэв. Тэд ч маш хурдан хүрч ирсэн Доктор И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуураар залбирал үйлдэв. (Үйлс 19:11-12). Тэгтэл гайхалтай зүйл болж огт ухаангүй байсан охин нүдээ нээн залбирал хийж өгсөн номлогч И Жей воны гараас нь барив. Халлелуяа! Хэд хоногын дараа биеийн сайжирч Маеай эмнэлэг рүү шилжүүлэн хэвтүүллээ. Мөн түүний эмч нь “Өвчтөн ухаан орсон ч тархи нь маш хүнд гэмтсэн учир насан туршидаа хөгжлийн бэрхшээлтэй” гэж хэлсэн билээ. Гэвч би итгэлээрээ охинд хоёр удаа залбирал хийж өгсөн юм. Тэгэхэд, тэр охин ярьж эхлэн бага багаар алхаж эхлэв. Одоо, тэрээр ямар ч хүндрэлгүйгээр алхаж чаддаг болсон ба хамгийн чухал нь тэрээр буддын сүсэгтэн байсан тэрээр Христчин болж жинхэнэ амийг олсон ба ийм гайхамшигт үйлсийн бий болгосон Бурхан Авдаа бүх л алдар ба талархалыг өргөн барья!



Гар алчуурын залбирлаар амьдарсан Мьянмар охин Ротчана Понсук

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь		залбирал цагийн хуваарь		
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойших мөргөл	Ням гариг 11: 30	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00			
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00			

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57-тоот

Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com